



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 1/236

Булган сум

Гамшгаас хамгаалах сургууль, дадлага, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.1, 10.3.2, 10.3.3, 10.3.5, 10.3.6, 13 дугаар зүйлийн 13.2.1, 13.2.5, 13.3.2, 13.3.3, 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.7, 32.1.8 дахь заалт, Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргын баталсан Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах хуваарийн дагуу зарим сумдад Гамшгаас хамгаалах сургууль, дадлага, бэлэн байдлын үзлэг, сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, оролцох сумдын нэр, зохион байгуулах хугацааг 2 дугаар, шаардагдах зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3."Гамшгаас хамгаалах сургууль, дадлага, бэлэн байдлын үзлэг"-ийн бэлтгэл ажлыг чанартай хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумын Засаг дарга нар (Б.Бямбажав, Э.Эрдэнэбулган, Х.Ундрахбаяр, Х.Ууганбаяр, Б.Жавзмаа, М.Ганболд, А.Ганбагана)-т, сургуулийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг гаргаж мэргэжлийн удирдлагаар ханган үр дүнтэй явуулахыг Онцгой байдлын газрын дарга (дэд хурандаа Н.Хишигдорж)-д тус тус даалгасугай.

4."Гамшгаас хамгаалах сургууль, дадлага, бэлэн байдлын үзлэг" зохион байгуулах ажлын хэсгийн зардал 11,477,404 (арван нэгэн сая дөрвөн зуун далан долоон мянга дөрвөн зуун дөрөв) төгрөгийг Байгаль хамгаалах сангийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010322

Аймгийн Засаг даргын 2026 оны
07 дугаар сарын 06 ны өдрийн 4236 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН БОЛОН КОМАНД ШТАБЫН СУРГУУЛЬ,
БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭР

Ажлын хэсгийн дарга:

Ж.Болдбаатар (Газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа)

Гишүүд:

Ж.Эрдэнэбулган (Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч, ахмад)

Г.Галмандах (Гамшгаас хамгаалах төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэгч, ахлах дэслэгч)

Б.Чулуунцэцэг (Гамшгийн эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч)

Э.Очирбат (Байгаль орчны газрын ойн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Н.Лхагвадорж (Мал эмнэлгийн газрын мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч)

Б.Ганчимэг (Эрүүл мэндийн газрын Яаралтай тусламж гамшгаас хамгаалах асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичиг:

М.Баттогтох (Сургалтын мэргэжилтэн, дэслэгч)

Жолооч

Д.Дашдэмбэрэл (Гал түймэр унтраах, аврах 20 дугаар ангийн гал унтраах автомашины жолооч, ахлах ахлагч)


Аймгийн Засаг даргын 2026 оны
09 дугаар сарын 06 ны өдрийн 2 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



“ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛЬ, ДАДЛАГА, БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ”
ЗОХИОН БАЙГУУЛАХ СУМДЫН НЭР

д/д	Сумдын нэр	Зохион байгуулах сургууль, дадлага, бэлэн байдлын үзлэг	Хугацаа
1	Сайхан сум	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль	2026 оны 04 дүгээр сарын 13-15-ны өдрүүдэд
2	Рашаант сум		2026 оны 04 дүгээр сарын 22-24-ний өдрүүдэд
3	Баян-Агт сум	Гамшгаас хамгаалах команд штабын сургууль	2026 оны 04 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд
4	Бүрэгхангай сум		2026 оны 04 дүгээр сарын 20-21-ний өдрүүдэд
5	Орхон сум	Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг	2026 оны 04 дүгээр сарын 27-нд
6	Сэлэнгэ сум		2026 оны 04 дүгээр сарын 28-нд
7	Бугат сум		2026 оны 04 дүгээр сарын 29-нд

Аймгийн Засаг даргын 20²⁶ оны
 04 дугаар сарын 06 ны өдрийн 4236 дугаар
 захирамжийн 3 дугаар хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛЬ, ДАДЛАГА, БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗӨХИОН
 БАЙГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Шатахууны зардал					
	Явах сумд	Зай хэмжээ	Шатахуун /литр/	Нийт үнэ		
1	Булган-Сайхан	100	Ландкрузер Лонг 00-74 БУН /ДТ/ 320км х 20л=64 литр	64 л х 4330 = 277,120		
	Сайхан-Баян-Агт	60				
	Баян-Агт- Булган	160				
	Дүн	320 км		277,120		
2	Булган-Бүрэгхангай	80	Ландкрузер Лонг 00-74 БУН /ДТ/ 440км х 20л=88 литр	88 л х 4330= 381,040		
	Бүрэгхангай-Рашаант	140				
	Рашаант-Булган	220				
	Дүн	440 км		381,040		
3	Булган-Орхон	23	Ландкрузер Лонг 00-74 БУН /ДТ/ 46 км х 20л=9,2 литр	9,2л х 4330= 39,836		
	Орхон-Булган	23				
	Дүн	46 км		39,836		
4	Булган-Сэлэнгэ	135	Ландкрузер Лонг 00-7 4 БУН /ДТ/ 288 км х 20л=57,6 литр	57,6 л х 4330= 249,408		
	Сэлэнгэ-Бугат	101				
	Бугат-Булган	52				
	Дүн	288 км		249,408		
5	Нийт	1094 км	218,8 литр	947,404 төгрөг		
Томилолтын зардал						
	Явах албан хаагчийн тоо	Нийт хоног	Томилолт /1 хоногийн/			Нийт
			Хоол	Байр	Нийт	
6	9	13	30,000	60,000	90,000	10,530,000
Бүгд дүн /төгрөг/						11,477,404